



ДУНДГОВЬ АЙМАГ
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 14 өдөр

Дугаар 8/57

Хажуу шинэ ус

Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийг
байгуулах тухай

Монгол улсын Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, 22 дугаар зүйлийн 22.1, 22.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль, төрийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, залуучуудын хөгжлийг дэмжих салбар дундын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах чиг үүрэг бүхий залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Залуучуудын боловсрол, соёл, эрүүл мэнд, биеийн тамир, хөдөлмөр эрхлэлт, хувь хүнийг хөгжүүлэх талаар олон талт үйл ажиллагааг жил бүр төлөвлөн, зохион байгуулж, үр дүнг тооцож ажиллахыг салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга (Д.Мандахцацрал)-д үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Д.Сарангэрэл)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ө.МӨНХ-АМГАЛАН



2021 оны 11 дугаар сарын
14 өдрийн тоот захирамжийн
хавсралт

Залуучуудын хөгжлийн салбар
зөвлөлийг бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн дарга	Ө.Мөнх-Амгалан (Засаг дарга)
Гишүүд	Н.Хүрэлбат (Ерөнхий боловсролын сургуулийн нярав) Э.Сувдмаа (Хөдөлмөр халамж, үйлчилгээний хэлтсийн мэргэжилтэн) Г.Амарбаяр (Архив, бичиг хэргийн эрхлэгч) Ж.Мөнхдэлгэр (эрүүл мэндийн төвийн их эмч) Э.Хишиг-Ундрал (Ерөнхий боловсролын сургуулийн багш) А.Бямбадорж (Мал эмнэлгийн байцаагч) Н.Ганбат (ЗДТГазрын нягтлан бодогч) Л.Батбаатар 4-р багийн Засаг дарга Ц.Батцэцэг (Хүүхдийн цэцэрлэгийн ажилтан) Б.Шижир-Эрдэнэ (Иргэний төлөөлөл) М.Бат-Эрдэнэ (Иргэний төлөөлөл) Т.Баасансүрэн (Иргэний төлөөлөл) Г.Амгаланбаатар (Иргэний төлөөлөл)
Нарийн бичгийн дарга	Д.Мандахцацрал (Нийгмийн бодлогын мэргэжилтэн)